

БООЦООТ МОРИН УРАЛДААНЫ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨНИЙ ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

ЗАХИАЛАГЧ: ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН ЯАМ

СУДЛААЧ: М.ЗОЛЗАЯА

АГУУЛГА

Ерөнхий зүйл

Нэг.Бооцоот морин уралдааны тухай хуулийн төсөлд үнэлгээ хийх шалгуур үзүүлэлтийг сонгох:

1. Зорилгод хүрэх байдал
2. Практикт хэрэгжих боломж
3. Ойлгомжтой байдал
4. Харилцан уялдаа.

Хоёр. Бооцоот морин уралдааны тухай хуулийн төслийн үр нөлөө үнэлэх хэсгээ тогтоох:

1. Зорилгод хүрэх байдал
2. Практикт хэрэгжих боломж
3. Ойлгомжтой байдал
4. Харилцан уялдаа.

Гурав.Хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх.

Дөрөв. Хуулийн төслийн үр дүнг үнэлж, зөвлөмж өгөх:

- 4.1. Үр дүнг баримтжуулах;
- 4.2. Үнэлэлт, дүгнэлт;
- 4.3. Зөвлөмж өгөх.

Тав.Ашигласан материалын жагсаалт.

БООЦООТ МОРИН УРАЛДААНЫ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛСЭН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Энэхүү үнэлгээний ажлын гол зорилго нь Бооцоот морин уралдааны тухай хуулийн төслийн зохицуулалт /зүйл, хэсэг, заалт/-д тодорхой шалгуур үзүүлэлтийн дагуу дүн шинжилгээ хийх, үр нөлөөг тооцож, давхардал, хийдэл, зөрчлийг арилгах, хуулийн зохицуулалтыг ойлгомжтой, хэрэгжих боломжтой байдлаар боловсруулах, улмаар хуулийн төслийн чанарыг сайжруулахад оршино.

Бооцоот морин уралдааны тухай хуулийн төсөл /цаашид “хуулийн төсөл” гэх/-ийн зохицуулалтын үр нөлөөг үнэлэхдээ Хууль тогтоомжийн тухай хууль¹, “Хуулийн төслийн үр нөлөө үнэлэх аргачлал²” /цаашид “аргачлал” гэх/-д заасны дагуу дараах үе шаттайгаар хийлээ:

1. Шалгуур үзүүлэлтийг сонгох;
2. Хуулийн төслөөс үр нөлөө үнэлэх хэсгээ тогтоох;
3. Шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгслийн дагуу үр нөлөөг тооцох;
4. Үр дүнг үнэлэх, зөвлөмж өгөх.

Хуулийн төслийн үнэлгээг Хууль зүй, дотоод хэргийн яамнаас боловсруулсан эхний хувилбар буюу ХЗДХС-ын холбогдох байгууллагуудаас санал авахаар 2022 оны 08 дугаар сарын 22-ны өдрийн 1/4295 тоот албан бичгээр хүргүүлсэн хувилбарт хийсэн болно.

НЭГ. ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ СОНГОСОН БАЙДАЛ, ҮНДЭСЛЭЛ

Тус үнэлгээний ажлыг хийж гүйцэтгэхдээ хуулийн төслийн зорилго, хамрах хүрээ, зохицуулах асуудалтай уялдуулан, аргачлалд дурдсан 6 шалгуур үзүүлэлтээс 4 шалгуур үзүүлэлтийг сонголоо. Үүнд:

1. Зорилгод хүрэх байдал
2. Практикт хэрэгжих байдал
3. Ойлгомжтой байдал
4. Харилцан уялдаа.

“Зорилгод хүрэх байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийг хуулийн төслийн зохицуулалтууд нь хуулийн төслийн үзэл баримтлалд тусгасан хуулийн төслийг боловсруулах болсон хэрэгцээ, шаардлагад нийцсэн эсэх /бүрэн илэрхийлж

¹ УИХ-аас 2015 оны 5 дугаар сарын 29-ний өдөр баталсан.

² Хууль тогтоомжийн тухай хуулийн 12.1-д заасны дагуу Монгол Улсын Засгийн газраас 2016 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан.

чадсан эсэх/-ийг тодорхойлох зорилгоор сонгов.

“Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтийг хуулийн төслийн зохицуулалтыг дагаж мөрдөх буюу хэрэгжүүлэх боломжтой эсэхийг, тухайлбал, хуулийг хэрэгжүүлэх субъект, байгууллага нь хэн байх вэ, тэдгээрт тухайн зохицуулалтыг хэрэгжүүлэх боломж, бололцоо /санхүү, хүний нөөц/ байгаа эсэхийг шалгаж тогтоох үүднээс сонгон авлаа.

“Ойлгомжтой байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийг хуулийн төсөл нь түүнийг хэрэглэх, хэрэгжүүлэх этгээдүүдийн хувьд ойлгомжтой, логик дараалалтай томъёологдсон эсэх, хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хууль, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан шаардлагыг хангасан эсэхийг хянах зорилгоор сонголоо.

“Харилцан уялдаа” гэсэн шалгуур үзүүлэлтийг хуулийн төслийн дотооддоо болон бусад хуультай уялдах уялдаа холбоог сайжруулах үүднээс хуулийн төслийн зүйл, хэсэг, заалт өөр хоорондоо болон хүчин төгөлдөр үйлчилж байгаа бусад хуульд нийцсэн эсэх, давхардал, хийдэл, зөрчил байгаа эсэхийг тогтоох зорилгоор аргачлалд заасан асуултад хариулах замаар шалгахаар сонгов.

Хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх шалгуур үзүүлэлтээс “хүлээн зөвшөөрөгдөх байдал”-ыг сонгоогүй бөгөөд Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлалын 4.8-д “Тухайн хуулийн төсөлд тодорхой этгээдэд үүрэг хүлээлгэсэн, хуулийн этгээдэд ачаалал, хүндрэл үүсгэх, эсхүл төрийн байгууллагад шинэ бүтэц бий болгох, чиг үүрэг нэмэх зэрэг зохицуулалт тусгасан бол “Хүлээн зөвшөөрөгдөх байдлын судалгаа хийх” гэсэн шалгах хэрэгслийн хүрээнд дараах байдлаар судалгаа хийнэ” гэж, 4.8.1-д “хуулийн төслийг хэрэгжүүлэх этгээд, төрийн бус байгууллагаас санал авах, санал асуулга явуулах, холбогдох байгууллага, этгээдийн хүрээнд ярилцлага, хэлэлцүүлэг явуулах зэргээр хуулийн төслийн зохицуулалтыг хүлээн зөвшөөрч байгаа эсэхийг судална” гэж заасан боловч хуулийн төслийг хэрэгжүүлэх этгээд нь уг хуулиар байгуулагдах нийтийн эрх зүйн этгээд байх тул асуулга явуулах боломжгүй байна.

Иймд “Хүлээн зөвшөөрөгдөх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлгээ хийж, бодит үр дүн гарахгүй тул тус шалгуурыг сонгоогүй болно.

ХОЁР. ХУУЛИЙН ТӨСЛӨӨС ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ХЭСГИЙГ ТОГТООСОН БАЙДАЛ

“Зорилгод хүрэх байдал” ш а л г у у р ү з ү ү л э л т и й н
х ү р э э н д :

Аливаа хуулийн зохицуулалт нь хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлагад нийцсэн байх ёстой учраас нэн түрүүнд хуулийн төслийн зорилгыг хуулийн төслийн үзэл баримтлалд тусгасан хэрэгцээ шаардлага, үндэслэл болон зорилготой харьцуулан үнэлэх хэсгээ тогтооно.

Бооцоот морин уралдааны тухай хуулийн төслийн үзэл баримтлал болон тандан судалгаагаар тус хуулийн төслийн үндсэн зорилго нь бооцоот морин уралдааны эрх зүйн орчныг бий болгох зорилгоор анхдагч хуулийн төсөл боловсруулна. Эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлэх, аялал жуулчлалыг хөгжүүлэх хүрээнд Монгол Улсын нутаг дэвсгэрт бооцоот морин уралдааны үйл ажиллагаа эрхлэх этгээдийг байгуулах, түүний чиг үүрэг, зохион байгуулалтын эрх зүйн үндсийг бүрдүүлэх, уралдаан зохион байгуулагчид тавигдах шаардлага, хориглох үйл ажиллагааг тогтоож, түүнд хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулна.³ гэжээ.

Иймд хуулийн төслийн зохицуулалт нь хуулийн төслийн зорилгыг хангахад чиглэсэн эсэхийг үнэлэх үүднээс хуулийн төслийн зорилго, зорилтод хүрэхэд чиглэсэн дараах зохицуулалтын үр нөлөөг үнэлэхээр сонголоо. Үүнд:

№	Зорилгод хүрэх байдал	Хуулийн төслийн сонгосон зүйл, хэсэг, заалт
1.	Монгол Улсын нутаг дэвсгэрт бооцоот морин уралдааны үйл ажиллагаа эрхлэх этгээдийг байгуулах, түүний чиг үүрэг, зохион байгуулалтын эрх зүйн үндсийг бүрдүүлэх, уралдаан зохион байгуулагчид тавигдах шаардлага, хориглох үйл ажиллагааг тогтоох.	<p><u>Хуулийн төслийн 12 дугаар зүйл. Морин уралдааны холбоо, түүний гишүүнчлэл</u></p> <p>12.1.Монголын морин уралдааны холбоо нь үндэсний өв соёл, уламжлал, морин уралдааныг олон нийтэд сурталчлан дэлгэрүүлэх зорилгоор энэ хуулийн дагуу байгуулагдсан, сайн дурын гишүүнчлэлтэй, өөрийн удирдлагатай, нийтийн эрх зүйн хуулийн этгээд байна.</p> <p><u>Хуулийн төслийн 13 дугаар зүйл. Морин уралдааны холбооны чиг үүрэг</u></p> <p>13.1.Холбоо дараах чиг үүрэгтэй байна:</p> <p>13.1.1.бооцоот уралдаан зохион байгуулах;</p> <p>13.1.2.морь амрах/сэрүүцүүлэх үйлчилгээ эрхлэх;</p> <p>13.1.3.бооцоот морин уралдааны үйл ажиллагааг хөгжүүлэх, сурталчлан дэлгэрүүлэх;</p> <p>13.1.4.мэргэжлийн боловсролын сургалтын байгууллагын үйл ажиллагаа эрхлэх;</p> <p>13.1.5.мэргэжлийн унаачийн эрх олгох.</p>

³ Бооцоот морин уралдааны тухай хуулийн үзэл баримтлал, 2022 он, 4 дүгээр тал

13.2.Холбоо дараах үүрэгтэй:

13.2.1.хууль тогтоомж болон Зөвлөлөөс тавьсан хууль ёсны шаардлагыг биелүүлэх;

13.2.2.зохих татварыг хуульд заасан журам, хэмжээгээр төлөх;

13.2.3.зориулалтын техник хэрэгсэл, сүлжээ, программ хангамж, хяналтын дууны, дүрс бичлэгийн төхөөрөмжөөр тоноглогдсон байх;

13.2.4.хууран мэхлэх, залилах, мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх болон бусад зохион байгуулалттай гэмт хэрэг үйлдэгдэхээс урьдчилан сэргийлэх;

13.2.5.мөнгө угаах, терроризмтэй тэмцэх тухай хууль тогтоомжийг мөрдөх, мөнгө угаах, терроризмтай тэмцэх үндэсний болон олон улсын байгууллагаас тавьж байгаа шаардлагыг биелүүлэх;

13.2.6.бооцоот уралдаан зохион байгуулах үйл ажиллагаандаа мөрдөж байгаа дүрэм, журам, аргачлалыг оролцогчид болон олон нийт танилцах боломжтой байдлаар нээлттэй байлгах, өөрчлөлт орсон тухай бүр шинэчлэх, бүртгүүлэх;

13.2.7.хуульд заасан бусад.

13.3.Холбоо бооцоот уралдаанд цугларсан нийт орлогын 60-аас доошгүй хувийг оролцогчдын бооцооны хонжвор, түрүүлсэн болон шагналт байранд орсон морины уяач, унаачийн шагналд олгох үүрэгтэй.

Хуулийн төслийн 8 дугаар зүйл. Бооцоот уралдаанд хориглох үйл ажиллагаа

8.1.Холбоонд бооцоот уралдааны үйл ажиллагаатай холбоотой дараах зүйлийг хориглоно:

8.1.1.оролцогч, уяач, унаачийг хууран мэхлэх зорилгоор уралдааны үр дүнг өөрчлөх, программ хангамжийн хэвийн үйл ажиллагааг алдагдуулах, хохироох;

8.1.2.хожсон оролцогч, уяач, унаачид хонжворыг төлөхөөс зайлсхийх, татгалзах;

8.1.3.морин тойруулгын дүрэм, бооцоот уралдаан зохион байгуулах, бооцоо тавих,

		<p>бооцоог хуваарилах дүрэм, бооцоот уралдааны мөнгөн кассын дүрмийг зөрчих;</p> <p>8.1.4.оролцогчоор дамжуулан бооцоо тавих, оролцогчийн бооцоо тавих шийдвэр гаргахад дотоод мэдээллийг ашиглуулах, давуу тал үүсгэх боломж олгох;</p> <p>8.1.5.санаатайгаар, эсхүл зохион байгуулалттайгаар шударга бусаар бооцоот уралдааны үр дүнд нөлөөлөх, уралдаанд оролцож байгаа унаач, морийг түрүүлүүлэх, хожигдуулахаар урьдаас үгсэн хуйвалдах;</p> <p>8.1.6.нийтээр хүлээн зөвшөөрсөн зан суртахууны хэм хэмжээнд харшилсан агуулгатай, эсхүл мөрийтэй тоглоомын донтолт үүсгэхүйц хэлбэрээр зар сурталчилгаа явуулах;</p> <p>8.1.7.Зөвлөлийн хориглосон бусад үйл ажиллагаа.</p> <p>8.2.Оролцогч, уяач, унаач, Холбоо болон бусад этгээд бооцоот уралдааны үр дүнд нөлөөлөх зорилгоор хуйвалдах, шударга бус үйлдлээр бооцоот уралдааны бусад оролцогчдын эрхийг зөрчих, хохирол учруулахыг хориглоно.</p>
2.	<p>Бооцоот морин уралдааны харилцаанд оролцох бусад этгээдүүд буюу бооцоо тавьж оролцогч, морин уралдааны унаач, уяачдын эрх зүйн байдлыг тодорхойлох.</p>	<p><u>Хуулийн төслийн 9 дүгээр зүйл. Оролцогч</u></p> <p>9.1.Бооцоот уралдаанд оролцогч нь 18 насанд хүрсэн Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүн байна.</p> <p>9.2.Холбоо нь Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн дагуу оролцогчийг таньж мэдэх үүрэгтэй байна.</p> <p><u>Хуулийн төслийн 10 дугаар зүйл. Уяач</u></p> <p>10.1.Бооцоот уралдаанд морио уралдуулах уяач Холбооны гишүүн байна. Бооцоот уралдаанд Холбооны гишүүнчлэлтэй уяач морио уралдуулах эрхтэй байна.</p> <p>10.2.Уяач өөрийн өмчлөлийн морийг бооцоот уралдаанд уралдуулахдаа морин тойруулгын дүрмийн дагуу Холбоонд бүртгүүлэх бөгөөд нэг морины бүртгэлд хоёроос дээш уяач бүртгэхгүй.</p> <p>10.3.Уяач өөрийн өмчлөлийн морийг бооцоот уралдаанд уралдуулахдаа сайн дураар даатгуулж болно.</p>

		<p>10.4.Уяач өөрийн өмчлөлийн морийг бооцоот уралдаанд уралдуулахад морин тойруулгын дүрмийг мөрдөх бөгөөд дүрмээр зохицуулаагүй харилцааг гэрээгээр тохиролцож болно.</p> <p><u>Хуулийн төслийн 11 дүгээр зүйл. Унаач</u></p> <p>11.1.Бооцоот уралдааны унаач нь морь уралдуулах чадвар, дадлыг эзэмшүүлэх морин уралдааны боловсрол олгох коллеж төгссөн, мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл бүхий 18 насанд хүрсэн хүн байна.</p> <p>11.2.18 насанд хүрээгүй хүнээр бооцоот уралдаанд морь унуулахыг хориглоно.</p> <p>11.3.Холбоо унаачийн хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангаж, шаардлага хангасан хамгаалалтын хувцас, хэрэглэлээр хангана.</p> <p>11.4.Унаач ослын даатгалд даатгуулсан байна.</p> <p>11.5.Унаачийг мэргэжлийн болон техникийн боловсрол эзэмшүүлэх сургалтын байгууллага бэлтгэх бөгөөд холбогдох харилцааг Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулиар зохицуулна.</p> <p>11.6.Бооцоот уралдааны аюулгүй байдлын дүрмийг Зөвлөл батална.</p> <p>11.7.Уралдуулсан морь нь бооцоот уралдаанд түрүүлсэн болон бооцоот уралдаанд шагналт байранд орсон тохиолдолд морин уралдааны бооцооноос олсон орлогоос уяач болон унаач нарын хүртэх хувь хэмжээг бооцоог хуваарилах дүрэм, аргачлалын дагуу олгоно.</p>
3.	<p>Бооцоот морин уралдаан зохион байгуулагчийн төлөх татварын төрөл, хувь хэмжээг тогтоож, төвлөрүүлсэн татварын орлогын зохих хувийг бэлчээрийн зохистой ашиглалт, нөхөн сэргээх ажиллагаа, болон соёлын өвийг хамгаалах, сэргээн засварлахад тус тус зарцуулах.</p>	<p><u>Хуулийн төслийн 21 дүгээр зүйл. Холбооны төлөх татварын орлого, зарцуулалт</u></p> <p>21.1.Уралдаан зохион байгуулах үйл ажиллагаанаас олсон орлогод Онцгой албан татварын тухай хуульд заасан албан татвар ногдуулна.</p> <p>21.2.Уралдааны хонжворын орлогод Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд заасан албан татвар ногдуулна. Холбоо татвар суутгагчийн үүрэг гүйцэтгэнэ.</p> <p>21.3.Энэ хуулийн 21.1-д заасны дагуу төвлөрүүлсэн татварын орлогын 15 хувийг бэлчээрийн зохистой ашиглалт, нөхөн сэргээх ажиллагаанд, мөн 15 хувийг соёлын өвийг</p>

		<p>хамгаалах, сэргээн засварлахад зориулан зарцуулна.</p> <p><u>Аж ахуй нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл</u></p> <p>1 дүгээр зүйл. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 21 дүгээр зүйлд дараах агуулгатай 21.1.15 дахь заалт нэмсүгэй:</p> <p>“21.1.15.онцгой албан татвар ногдуулсны дараах казино, бооцоот морин уралдааны үйл ажиллагаанаас олсон орлого.”</p>
4.	<p>Мөрийтэй тоглоомын үйл ажиллагаанд төрийн зүгээс тавих хяналтыг хэрэгжүүлэх, зохицуулах чиг үүрэг бүхий Зөвлөлийн бооцоот уралдааны үйл ажиллагаатай холбоотойгоор хэрэгжүүлэх чиг үүргийг нарийвчлан тусгах.</p>	<p><u>Хуулийн төслийн 23 дугаар зүйл. Бооцоот уралдааны үйл ажиллагаанд хийх хяналт шалгалт</u></p> <p>23.1. Зөвлөлийн ажлын алба бооцоот уралдаан зохион байгуулах үйл ажиллагаанд төлөвлөгөөт бус, эсхүл гүйцэтгэлийн хяналт шалгалт хийнэ.</p> <p>23.2. Уралдаан зохион байгуулах үйл ажиллагааны талаар иргэн, хуулийн этгээдээс гомдол ирсэн тохиолдолд төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийх бөгөөд Холбоонд хүргүүлсэн хугацаатай албан шаардлагын биелэлтийг шалгах зорилгоор гүйцэтгэлийн хяналт шалгалт хийнэ.</p> <p>23.3. Улсын байцаагч нь дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:</p> <p>23.3.1. бооцоот морин уралдааны хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих;</p> <p>23.3.2. хяналт шалгалтын ажилд шаардлагатай мэдээлэл, баримт бичгийг холбогдох байгууллага, албан тушаалтанаас үнэ төлбөргүй гаргуулан авах;</p> <p>23.3.3. хяналт шалгалт хийх объектод саадгүй нэвтрэн орох, хяналт шалгалтын явцад зөрчлийн ул мөр, нотлох баримт цуглуулах, зөрчлийн талаарх ач холбогдол бүхий бусад байдлыг тодруулах зорилгоор шалгагдаж байгаа этгээдийн бие, албан тасалгаа, бичиг баримт, компьютер, эд зүйлд үзлэг хийх, шаардлагатай баримт материал, эд зүйлийг түр хураан авах;</p> <p>23.3.4. бооцоот уралдааны үйл ажиллагааны явцын хяналтын дуу, дүрс, бичлэгийг шалгах;</p>

	23.3.5.хууль тогтоомжид заасан бусад эрх, үүрэг.
--	--

“Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтийн хүрээнд:

Хуулийн төсөлд шинээр бий болгож байгаа чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбоотой дараах зохицуулалтыг хэрэгжүүлэх субъект хэн байх вэ, тэдгээр нь уг зохицуулалтыг дагаж мөрдөх буюу хэрэгжүүлэх боломжтой эсэхийг шалган тогтоох үүднээс сонгон авлаа.

1. Хуулийн төслийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг:

5.1.Бооцоот уралдааныг Засгийн газрын эрх олгосноор Монголын морин уралдааны холбоо /цаашид “Холбоо” гэх/ зохион байгуулна.

2. Хуулийн төслийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэг:

12.1.Монголын морин уралдааны холбоо нь үндэсний өв соёл, уламжлал, морин уралдааныг олон нийтэд сурталчлан дэлгэрүүлэх зорилгоор энэ хуулийн дагуу байгуулагдсан, сайн дурын гишүүнчлэлтэй, өөрийн удирдлагатай, нийтийн эрх зүйн хуулийн этгээд байна.

3. Хуулийн төслийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсэг:

13.1.Холбоо дараах чиг үүрэгтэй байна:

- 13.1.1.бооцоот уралдаан зохион байгуулах;
- 13.1.2.морь амраах/сэрүүцүүлэх үйлчилгээ эрхлэх;
- 13.1.3.бооцоот морин уралдааны үйл ажиллагааг хөгжүүлэх, сурталчлан дэлгэрүүлэх;
- 13.1.4.мэргэжлийн боловсролын сургалтын байгууллагын үйл ажиллагаа эрхлэх;
- 13.1.5.мэргэжлийн унаачийн эрх олгох.

“Ойлгомжтой байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн зохицуулалт түүнийг хэрэглэх, хэрэгжүүлэх субъектүүдийн хувьд ойлгомжтой, логик дараалалтай боловсруулагдсан эсэхийг шалгах, хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хууль, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан шаардлагыг хангасан эсэхийг шалгах тул хуулийн төслийг бүхэлд нь шалгах аар сонгов.

“Харилцан уялдаа” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн зохицуулалт өөр хоорондоо болон хуулийн төслийг бусад

хуультай нийцсэн, уялдсан эсэхийг шалгах тул бүхэлд нь шалгахаар сонголоо.

ГУРАВ.ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТЭД ТОХИРОХ ШАЛГАХ ХЭРЭГСЛИЙН ДАГУУ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛСЭН БАЙДАЛ

Аргачлалд заасны дагуу хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх шалгуур үзүүлэлт, үр нөлөөг үнэлэх хэсгийг дээрх 2 үе шатанд тус тус тогтоосны дагуу тэдгээрт тохирох шалгах хэрэгслийг дараах байдлаар тодорхойллоо:

Д/д	Шалгуур үзүүлэлт	Үр нөлөөг үнэлэх	Тохирох шалгах хэрэгсэл
1.	Зорилгод хүрэх байдал	Энэхүү үнэлгээний тайлангийн Хоёр дахь хэсэг буюу Зорилгод хүрэх байдал шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлэхээр сонгосон зохицуулалтууд. /Үнэлгээний тайлангийн 5-9 дүгээр хуудас/	Зорилгод дүн шинжилгээ хийх: Хуулийн төслийн зохицуулалт нь төслийн үзэл баримтлалд дурдсан хэрэгцээ, шаардлагад нийцсэн эсэхэд дүн шинжилгээ хийнэ.
2.	Практикт хэрэгжих боломж	Хуулийн төслийн 5 дугаар зүйлийн 5.1, 12.1, 13.1 дэх хэсэг	Санал авч, дүн шинжилгээ хийх: Уг зохицуулалтыг хэрэгжүүлэх байгууллага дээр туршилт хийх боломжгүй тул адил төстэй үйл ажиллагаа явуудаг хуулийн этгээдийн мэдээлэл болон олон улсын туршлага, эрх зүйн зохицуулалтын хүрээнд үнэлэх замаар шалгана.
3.	Ойлгомжтой байдал	Хуулийн төсөл бүхэлдээ /Хуулийн төсөл 7 бүлэг, 25 зүйлтэй/	Ойлгомжтой байдлыг шалгах: Хуулийн төсөлд хамаарах этгээдүүдээс уг төсөл нь ойлгомжтой байдлаар томъёологдсон эсэхийг шалгах, түүнчлэн Хууль тогтоомжийн тухай хууль, “Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлал”-ыг баримталсан эсэхийг шалгана.
4.	Харилцан уялдаа	Хуулийн төсөл бүхэлдээ /Хуулийн төсөл 7 бүлэг, 25 зүйлтэй/	Хуулийн төслийн уялдаа холбоог шалгах: Хуулийн төслийн уялдаа холбоог аргачлалын 4.10-т заасан асуултад хариулах замаар шалгана.

Дээрх урьдчилан сонгож авсан шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгслийн дагуу

хуулийн төсөлд үр нөлөөний үнэлгээг дараах байдлаар хийв.

3.1.“Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ:

Энэ шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн зохицуулалт нь хуулийн төсөл боловсруулах болсон хэрэгцээ, шаардлагад нийцсэн эсэхийг шалгахын тулд хуулийн төслийн үзэл баримтлалд³ тусгасан хэрэгцээ шаардлагыг хуулийн төсөлд хэрхэн тусгасныг тогтоох, эдгээр зохицуулалт нь үзэл баримтлалд тодорхойлсон хэрэгцээ, шаардлагад нийцэж байгаа эсэхийг харьцуулан дүн шинжилгээ хийлээ.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого”-ын 4.2-т “Эдийн засгийн тэргүүлэх салбаруудыг хөгжүүлж, экспортын баримжаатай эдийн засгийг бий болгох” гэж, 8.2-т “Эдийн засгийн тэргүүлэх салбарууд болон байршлын давуу талд тулгуурлан бүс, орон нутагт аялал жуулчлалыг хөгжүүлнэ” гэж тус тус заасан.

Тус хөгжлийн бодлогын хүрээнд “Үндэсний онцлог бүхий аялал жуулчлалыг хөгжүүлж, олон улсын аялал жуулчлалын зах зээлд өрсөлдөх чадвар дээшилсэн байх” зорилтыг дэвшүүлж, 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны 4.2.47-д “...аялал жуулчлалын томоохон төв, паркуудыг байгуулж, шашин, соёл, спорт, адал явдалт аялал зэрэг улирлын хамаарал багатай аялал жуулчлалыг хөгжүүлнэ” гэж заасан.

Түүнчлэн Монгол Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.4-т Байгаль, түүх, соёлын өвд түшиглэсэн тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх бодлогын хүрээнд “Аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээ, чанар, стандартыг сайжруулж, өрсөлдөх чадварыг дээшлүүлэн, иргэд, жуулчдын тоог нэг саяд хүргэнэ” гэж, мөн 2.6-д заасан Үндэсний үнэт зүйл, уламжлалт өв соёлоо дээдэлж, иргэдийг соён гэгээрүүлж, соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлэн, дэлхийн нүүдлийн соёл иргэншлийн төв болох зорилтын хүрээнд “... соёлын аялал жуулчлал, кино урлаг, сонгодог урлагийн бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрлийг олшруулан, эдийн засгийн эргэлтэд оруулна” гэж тус тус заасан.

Мөн Засгийн газрын 2019 оны 333 дугаар тогтоолоор баталсан Төрөөс аялал жуулчлалыг хөгжүүлэх талаар баримтлах бодлогын хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээний 4.1.16-д эдийн засгийн өндөр үр өгөөжтэй аялал жуулчлалын хэлбэрүүдийг хөгжүүлэх хүрээнд Хурдан морины бооцоот уралдааны тухай хуулийн төслийг боловсруулан, батлуулахаар тусгажээ.

Дээрх бодлогын баримт бичигт тусгасан зорилго, зорилтыг хэрэгжүүлэх үүднээс Бооцоот морин уралдааны тухай хуулийн төслийг боловсруулах үндэслэл, хэрэгцээ шаардлага

гарсан байх бөгөөд хуулийн төслийн үзэл баримтлалд тусгасан хэрэгцээ шаардлагыг хуулийн төсөлд хэрхэн тусгасан, түүнчлэн хуулийн төсөлд бүрэн дүүрэн, хангалттай тусгаж чадсан эсэхэд дараах байдлаар үнэлэлт, дүгнэлт хийлээ. Үүнд:

1.Монгол Улсын нутаг дэвсгэрт бооцоот морин уралдааны үйл ажиллагаа эрхлэх этгээдийг байгуулах, түүний чиг үүрэг, зохион байгуулалтын эрх зүйн үндсийг бүрдүүлэх, уралдаан зохион байгуулагчид тавигдах шаардлага, хориглох үйл ажиллагааг тогтоох.

Энэ хэрэгцээ шаардлагын хүрээнд хуулиар бооцоот морин уралдааны үйл ажиллагаа эрхлэх нийтийн эрх зүйн этгээдийг байгуулж, зохион байгуулалтын бүтцийг нарийвчлан тусгаснаас гадна хуулийн этгээдийн гүйцэтгэх чиг үүргийг тодорхой зааснаас гадна бооцоот морин уралдаанд хориглох үйл ажиллагааг тогтоосон нь үзэл баримтлалын дээрх хэрэгцээ шаардлагад нийцсэн байна.

Тухайлбал нийтээр хүлээн зөвшөөрсөн зан суртахууны хэм хэмжээнд харшилсан агуулгатай, эсхүл мөрийтэй тоглоомын донтолт үүсгэхүйц хэлбэрээр зар сурталчилгаа явуулахыг хориглосноос гадна оролцогчийг бооцоот уралдаанд зээлээр оролцуулах, морин тойруулгын цогцолборт барьцаалан зээлдүүлэх үйлчилгээ эрхлэхийг хориглосон зохицуулалтыг тусгасан нь олон нийтийг бооцоот тоглоомонд донтохоос урьдчилан сэргийлэх зорилгод нийцэж байна.

Харин үзэл баримтлалд бооцоот морин уралдаан зохион байгуулагчид тавигдах шаардлагыг тогтоохоор заасан боловч хуулийн төсөлд зөвхөн морин тойруулгад тавигдах шаардлагыг тусгасан бөгөөд бооцоот морин уралдаан зохион байгуулагчид тавигдах шаардлагыг тусгаагүй болохыг анхаарах нь зүйтэй байна.

Хуулийн төсөлд тусгаснаар бооцоот морин уралдаан зохион байгуулах цорын ганц этгээд нь энэ хуулиар байгуулагдах Холбоо байх бөгөөд тухайн этгээдэд хууль тогтоомж болон Зөвлөлөөс тавьсан хууль ёсны шаардлагыг биелүүлэх үүргийг хүлээлгэсэн зохицуулалтын хүрээнд тухайн этгээдэд тавигдах шаардлагыг хуулиар тогтоох хэрэгцээ хангагдах эсэхийг дахин нягтлах шаардлагатай байна.

2.Бооцоот морин уралдааны харилцаанд оролцох бусад этгээдүүд буюу бооцоо тавьж оролцогч, морин уралдааны унаач, уяачдын эрх зүйн байдлыг тодорхойлох.

Энэ хэрэгцээ шаардлагын хүрээнд хуулийн төслийн гуравдугаар бүлэгт бооцоот морин уралдаанд 18 насанд хүрсэн Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүн бооцоо тавьж оролцож болохоор, мөн уяач нь Холбооны гишүүнчлэлтэй тохиолдолд морио уралдуулах боломжтой болохыг тодорхой заасан нь тухайн харилцаанд оролцогчдод тодорхой, ойлгомжтой болсон байна.

Мөн бооцоот морин уралдааны зохион байгуулагч нь “бооцоот уралдаанд цугларсан нийт орлогын 60-аас доошгүй хувийг оролцогчдын бооцооны хонжвор, түрүүлсэн болон шагналт байранд орсон морины уяач, унаачийн шагналд олгох” үүргийг тусгасан нь оролцогч этгээдүүдийн эрх ашгийг хамгаалах агуулгыг тусгасан нь үзэл баримтлалын дээрх хэрэгцээ шаардлагад

нийцсэн байна. Түүнчлэн 18 насанд хүрээгүй хүнээр бооцоот уралдаанд морь унуулахыг хориглосон нь унаач хүүхдийн эрхийн асуудал хөндөгдөхөөргүй байна.

Харин унаач нь морь уралдуулах чадвар, дадлыг эзэмшүүлэх морин уралдааны боловсрол олгох коллеж төгссөн, мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй этгээд байх шаардлагыг тусгасан нь хэрэгцээ шаардлагыг хангаж байгаа хэдий ч хэрэгжүүлэх этгээдийн тухайд тодорхойгүй нөхцөл байдал үүсч болзошгүй байна.

Тодруулбал Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.4-т “ажил мэргэжлийн үндэсний ангилал, тодорхойлолт, мэргэжлийн стандарт, мэргэжлийн боловсрол, сургалтын агуулгыг хэлэлцэж дүгнэлт гаргах” асуудал нь Мэргэжлийн боловсрол, сургалтын Үндэсний зөвлөлийн бүрэн эрх хамаарна.

9 дүгээр зүйлийн 9.1-д “Мэргэжлийн боловсрол эзэмшүүлэх сургалтын агуулга нь суралцагчид ажил, мэргэжлийн үндэсний ангиллаар тодорхойлсон мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэхэд шаардагдах мэдлэг, чадвар, дадал эзэмшүүлж, төлөвшүүлэхэд чиглэнэ” гэж заасан бөгөөд ажил, мэргэжлийн үндэсний ангилал болох “YAMAT-08”-ыг Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын 2010 оны 2 дугаар сарын 10-ны өдрийн “Үндэсний ажил, мэргэжил, албан тушаалын жагсаалт, ангилал, тодорхойлолт батлах тухай” 16 дугаар тушаалаар баталсан байна.

Дээрх “Үндэсний ажил, мэргэжлийн ангилал”-д унаачын ажил, мэргэжил хамаарахгүй байх тул унаачын мэргэжлийн боловсрол эзэмшүүлэх сургалтын агуулгыг тодорхойлох эрх зүйн үндэслэлгүй болохыг анхаарах шаардлагатай гэж үзэж байна.

3.Бооцоот морин уралдаан зохион байгуулагчийн төлөх татварын төрөл, хувь хэмжээг тогтоож, төвлөрүүлсэн татварын орлогын зохих хувийг бэлчээрийн зохистой ашиглалт, нөхөн сэргээх ажиллагаа, болон соёлын өвийг хамгаалах, сэргээн засварлахад ажиллагаанд тус тус зарцуулах.

Татвартай холбоотой харилцааг хуулийн төсөлд тусгаж, дагалдах хуулийн төслүүдийг боловсруулсан нь үзэл баримтлалд заасан уг хэрэгцээ шаардлагад нийцсэн байна.

Харин татварын хувь хэмжээ тогтоосон нэмэлт, өөрчлөлтүүдийн зарим зохицуулалтыг Бооцоот таавар, хонжворт сугалааны тухай хуулийн төслийг дагалдуулж боловсруулсан байна.

Тодруулбал Онцгой албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл зэрэг болно. Хэдийгээр Казиногийн тухай, Бооцоот таавар, хонжворт сугалааны тухай, Бооцоот морин уралдааны тухай хуулийн төслүүд нь хамтаар боловсруулагдаж байгаа боловч тус тусын үзэл баримтлалын хүрээнд боловсруулагдаж байгаа тул дагалдаж

боловсруулах хуулийн төслүүдийг нэгтгэх боломжгүйг анхаарах шаардлагатай байна.

Түүнчлэн Онцгой албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд “бооцоот морин уралдааны үйл ажиллагаа эрхэлж байгаа татвар төлөгчийн үйл ажиллагааны нийт орлогоос хонжворт олгосон дүнг хассан дүнгийн 60 хувиар” татвар ногдуулахаар заасан байна. Хуулийн төсөлд “бооцоот морин уралдааны үйл ажиллагаа” гэдгийг хэрхэн ойлгох талаар нэр томъёоны тайлбар байхгүй бөгөөд хуулийн төслийг бүхэлд нь авч үзвэл Холбооны гүйцэтгэх чиг үүрэг /бооцоот уралдаан зохион байгуулах;, морь амраах/сэрүүцүүлэх үйлчилгээ эрхлэх;, бооцоот морин уралдааны үйл ажиллагааг хөгжүүлэх, сурталчлан дэлгэрүүлэх;, мэргэжлийн боловсролын сургалтын байгууллагын үйл ажиллагаа эрхлэх;, мэргэжлийн унаачын эрх олгох/-ийг нийтэд нь “бооцоот морин уралдааны үйл ажиллагаа” гэж ойлгохоор байна. Энэ нь эргээд татвар ногдуулах орлогыг тооцоход төөрөгдөл үүсгэж болзошгүй байна.

Мөн хуулийн төсөлд албан татвар, төлбөр, хураамж тогтоогоогүй боловч татвар ногдуулахтай холбоотой зохицуулалтыг тусгасан байх тул нарийвчилсан зохицуулалтыг татварын тухай хуулиар тусгах нь зүйтэй гэж үзлээ.

4.Мөрийтэй тоглоомын үйл ажиллагаанд төрийн зүгээс тавих хяналтыг хэрэгжүүлэх, зохицуулах чиг үүрэг бүхий Зөвлөлийн бооцоот уралдааны үйл ажиллагаатай холбоотойгоор хэрэгжүүлэх чиг үүргийг нарийвчлан тусгах.

Хуулийн төсөлд мөрийтэй тоглоомын үйл ажиллагаанд хяналт тавих, зохицуулах үүрэг бүхий Зөвлөлийн чиг үүргийг тодорхойлж, өөрийн ажлын албаар дамжуулан бооцоот морин уралдааны үйл ажиллагаанд хяналт тавихаар тусгасан нь үз э л баримтлалд заасан уг хэрэгцээ шаардлагад нийцсэн гэж үзэж болохоор байна.

Зөвлөлийн ажлын алба нь төлөвлөгөөт бус болон гүйцэтгэлийн гэсэн 2 хэлбэрээр хяналт тавихаар тодорхой заасан боловч хяналтыг хэрхэн, ямар хугацаанд, ямар байдлаар тавих нь тодорхойгүй байх тул уг асуудлыг нягталж, журамлах шаардлагатай эсэхийг тодорхойлох нь зүйтэй байна.

3.2.“Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ:

“Практикт хэрэгжих боломж” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс сонгож авсан дээрх зохицуулалтыг дагаж мөрдөх болон хэрэгжих боломжтой эсэхийг, тухайлбал, хуулийн төслийн эдгээр зохицуулалтыг хэрэгжүүлэх субъект нь хэн байх, тэдгээрт энэхүү зохицуулалтыг хэрэгжүүлэх боломж,

бололцоо /санхүү, хүний нөөц зэрэг/ байгаа эсэхийг шалгахыг зорилоо.

Практикт хэрэгжих байдал гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төсөлд тусгасан эрх зүйн зохицуулалтууд нь бодитой хэрэгжих боломжтой эсэхийг судлах замаар үр нөлөөг үнэлэх бөгөөд хуулийн төсөлд тусгаснаар бооцоот морин уралдааны үйл ажиллагааг “Монголын морин уралдааны холбоо” /цаашид “Холбоо” гэх/ зохион байгуулахаар заасан бөгөөд тухайн Холбоог энэ хуулиар үүсгэн байгуулж байна.

Иймд туршилт явуулахад хамрагдах холбогдох байгууллага, этгээд байхгүй тул туршилт явуулах боломжгүй гэж үзээд, адил төстэй үйл ажиллагаа явуулдаг хуулийн этгээдийн мэдээлэлд үнэлгээ хийхээс гадна, олон улсын туршлага, эрх зүйн зохицуулалтын хүрээнд үнэлнэ.

1. Хуулийн төслийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг:

5.1.Бооцоот уралдааныг Засгийн газрын эрх олгосноор Монголын морин уралдааны холбоо /цаашид “Холбоо” гэх/ зохион байгуулна.

2. Хуулийн төслийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэг:

12.1.Монголын морин уралдааны холбоо нь үндэсний өв соёл, уламжлал, морин уралдааныг олон нийтэд сурталчлан дэлгэрүүлэх зорилгоор энэ хуулийн дагуу байгуулагдсан, сайн дурын гишүүнчлэлтэй, өөрийн удирдлагатай, нийтийн эрх зүйн хуулийн этгээд байна.

3. Хуулийн төслийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсэг:

13.1.Холбоо дараах чиг үүрэгтэй байна:

- 13.1.1.бооцоот уралдаан зохион байгуулах;
- 13.1.2.морь амрах/сэрүүцүүлэх үйлчилгээ эрхлэх;
- 13.1.3.бооцоот морин уралдааны үйл ажиллагааг хөгжүүлэх, сурталчлан дэлгэрүүлэх;
- 13.1.4.мэргэжлийн боловсролын сургалтын байгууллагын үйл ажиллагаа эрхлэх;
- 13.1.5.мэргэжлийн унаачийн эрх олгох.

➤ Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн нээлтэй мэдээллийн сан⁴-гаас үзэхэд хурдан морины уралдааны чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг нийт 96 төрийн бус байгууллага бүртгэгдснээс нийтэд үйчилдэг төрийн бус байгууллага 87, гишүүддээ үйлчилдэг төрийн бус байгууллага 19 байна. Эдгээр төрийн бус байгууллагаас нэг хуулийн этгээд ашгийн төлөө үйл ажиллагаа эрхэлдэг бол нийт 95 төрийн бус байгууллага морин уралдааны чиглэлээр ашгийн бус үйл ажиллагаа эрхэлж байна.

Дээрх төрийн бус байгууллагууд үйл ажиллагааны чиглэлийг үзвэл морин спортын уралдааны төрлийг хөгжүүлэх, зохион байгуулах, сурталчлах зэрэг үйл ажиллагаа нийтлэг байдлаар эрхлэхээс гадна, хурдан морины үүлдэр угсаа, угшлыг

⁴ <http://opendata.burtgel.gov.mn/>

тодорхойлох, сайжруулах зорилгоор үйл ажиллагаа явуулдаг байна. Хэдийгээр эрх зүйн орчин байхгүй боловч мэргэжлийн унаач буюу жокей бэлтгэдэг⁵ байна.

- Бооцоот морин уралдааны үйл ажиллагаа нь дэлхийн улс орнуудад практикт туршигдсан, хэрэгжих боломжтой болох нь дараах судалгаануудаас харагдаж байна. Үүнд:

Хонг Конг

Хонг Конгийн Жокэй Клуб нь ойролцоогоор 135 жилийн түүхтэй ашгийн төлөө бус байгууллага бөгөөд Хонг Конгод монополь эрхтэйгээр бооцоот морин уралдаан зохион байгуулдаг. 7 хоногийн 2 өдөр морин уралдаан зохион байгуулах бөгөөд бооцооноос цугласан орлогоос бооцоо тавигчдад буцаан өгсөн дүнг хассаны дараах дүнгийн 72,5 хувийг татварт төлдөг байна.⁶ (Харин бооцооны хожлоос ХХОАТ авдаггүй) Тус байгууллага нь Хонконгийн хамгийн том татвар төлөгч төдийгүй олон нийтийн хамгийн том буяны байгууллага юм.

Хүн амын тоо олон, нэг л байгууллага монополь эрхтэйгээр үйл ажиллагаа явуулдаг, бусад төрлийн бооцоотой, мөрийтэй тоглоом хууль бус байдаг зэргээс шалтгаалан морин уралдаан үзэгч, бооцоот уралдаанаас олох орлого нь жилээс жилд буурахгүй, харин өсөх хандлагатай байдгаараа онцлог байна. Түүнчлэн клуб нь 4 төрлийн гишүүнчлэлтэй бөгөөд гишүүнчлэлийг олгох шалгуур нь өндөр тул энэ нь тухайн хүний нийгэм дэх байр суурь, нэр хүндийн илэрхийлэл болдог нь мөн нөлөөлдөг байна. 2013 оны байдлаар гишүүнчлэлийн хураамж 400,000 хонконг доллар, сар бүр 1,800 хонконг долларын хураамжтай бөгөөд гишүүнчлэлийг дамжуулан худалдаж авахыг зөвшөөрдөггүй байна.

Эстони

Эстони Улсын Мөрийтэй тоглоомын тухай хууль нь бүх төрлийн мөрийтэй, бооцоот тоглоомын харилцаанд үйлчлэхээр зохицуулсан бөгөөд үүнд бооцоот морин уралдаанд мөрий тавих харилцаа хамаарч байна. Уг харилцаатай холбоотой татварын маргаан шийдвэрлэлт, татварын байгууллагын эрх, үүргийн талаар Татварын тухай хуульд, мөрийтэй тоглоомтой холбоотой мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс сэргийлэх санхүүгийн тогтолцоо, эдийн засгийн орон зайн талаар Мөнгө угаах, терроризмтэй тэмцэх тухай хуульд, Зар сурталчилгааны тухай хуулиар мөрийтэй тоглоомыг сурталчлахтай холбоотой хориглох талаар зохицуулсан байдаг. Хамгийн сүүлийн мөрийтэй тоглоомын тухай хуулийг 2008 онд баталж, 2009 оны эхээр хүчин төгөлдөр болсон.

Энэхүү хууль тогтоомжийн гол давуу тал нь хурдацтай хөгжиж буй онлайн мөрийтэй тоглоомын салбарыг зохицуулах эрх зүйн үндсийг бүрдүүлж өгсөн явдал юм. Энэхүү хууль нь өнөөгийн Эстони улсад мөрийтэй тоглоомын салбарыг зохицуулдаг. Энэхүү акт хүчин төгөлдөр болохоос өмнө хоёр үндсэн хууль тогтоомжийг ашиглаж байсан - 1995 оны мөрийтэй тоглоомын тухай хууль, 1994 оны сугалааны тухай хууль. Мөрийтэй тоглоомын салбар дахь технологийн хурдацтай хөгжлийн улмаас эдгээр хоёр акт тун удалгүй хангалтгүй болсон. Ялангуяа онлайн мөрийтэй тоглоомын үйлчилгээ зохицуулалтгүй хэвээр үлдсэн байна.

1995 онд батлагдсан Мөрийтэй тоглоомын тухай хууль нь мөрийтэй тоглоомын 4 төрлийг, тухайлбал, азын тоглоом, ур чадварын тоглоом, тотализатор, бооцоо зэргийг нэвтрүүлсэн. Энэхүү хуулийн дагуу мөрийтэй тоглоомын үйлчилгээ эрхлэх боломжтой

⁵ <https://gogo.mn/r/e7v38>

⁶ <https://www.ird.gov.hk/eng/tax/bdu.htm>

байхын тулд бүх операторууд үйл ажиллагааны лиценз, үйл ажиллагааны зөвшөөрөл авсан байх ёстой. Бүх төрлийн мөрийтэй тоглоомын үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийг 10 жилийн хугацаатайгаар олгохоор тусгасан. Ашиглалтын зөвшөөрлийг 5 жилийн хугацаатай бөгөөд мөрийтэй тоглоомын газар хаана ажилууллахыг зааж өгсөн байна. Тусгай зөвшөөрлийн өргөдөл нь татгалзсан өргөдөл гаргагчид асуудлыг шийдвэрлэхийн тулд захиргааны хэргийн шүүхэд хандах боломжтой байна.

Мөрийтэй тоглоомын тухай шинэ хууль нь өмнөх 2 үйлдлийг хүчингүй болгосон боловч ихэнх гол зохицуулалтууд өөрчлөгдөөгүй хэвээр үлджээ. Ялангуяа 1995 онд Мөрийтэй тоглоомын тухай хуульд заасан 4 төрлийн мөрийтэй тоглоомыг шинэ хуульд мөрийтэй тоглоомын үндсэн ангилал гэж тодорхойлсон болно. Мөрийтэй тоглоомын үйлчилгээг хууль ёсны дагуу санал болгох үйл ажиллагааны зөвшөөрөл авах шаардлага мөн өөрчлөгдөөгүй хэвээр байна. Эстони нь Европын холбооны гишүүн улс тул мөрийтэй тоглоомын тухай хууль нь Олон нийтийн хууль тогтоомжид нийцсэн байх ёстой. Гэсэн хэдий ч ЕХ-ны бусад орнуудад тусгай зөвшөөрөл авсан операторууд ч зөвшөөрөлгүй хүмүүсийн адил шаардлагыг хангаж, өөрөөр хэлбэл үйл ажиллагаа, ашиглалтын тусгай зөвшөөрөл хүсч өргөдөл гаргаж, Эстонийн татвар, гаалийн зөвлөлд хууль эрх зүйн болон тогтвортой байдлыг хангах чадвартай гэдгээ нотолж өгөх ёстой. Эдгээр хатуу дүрмүүд нь Европын Комиссоос сурталчилж буй чөлөөт өрсөлдөөний зарчмуудтай зөрчилдөж байгаа боловч Эстонийн эрх баригчид мөрийтэй тоглоомын салбарыг зохих журмын дагуу зохицуулж байна.

Кени Улс

Кенийн Үндэсний Ассемблей нь бооцоот тоглоомын зохицуулалтын хүрээг шинэчлэн боловсруулж, тусгай зөвшөөрөлтэй оператор компаниудад илүү өндөр зардал ногдуулж, тус улсын анхны үндэсний сугалааг байгуулах хуулийн төслийг хэлэлцэж 2018 онд нэмэлт, өөрчлөлт оруулсан байна. 1966 оны бооцоо, хонжворт сугалаа, бооцоот тоглоомын тухай хуулийг орлох зорилгоор боловсруулсан Тоглоомын тухай хуулийг 2019 онд онлайн операторуудын зах зээл дээрх тэргүүлэх байр суурийг тусгах зорилгоор тус улсын журмыг шинэчлэх зорилготойгоор хуулийн төслийг шинэчилж байгаа бөгөөд энэ нь тус улсын одоо байгаа зохицуулах эрх бүхий байгууллага болох Бооцоо тоглоомын тусгай зөвшөөрлийн хяналтын зөвлөлийг шинэ тоглоомын газар болох Үндэсний тоглоомын газартай хамт солихыг санал болгож байна. Хуулийн төсөлд шинэ зохицуулах байгууллага байгуулахын зэрэгцээ бооцоот тоглоомтой холбоотой маргааныг хянан шийдвэрлэх байгууллага болох Тоглоомын хэргийн давж заалдах шатны шүүхийг байгуулахаар тусгажээ.

Морин уралдаанд бооцоо тавих харилцааг хуулиар зөвшөөрч, олон жил практикт хэрэгжүүлсэн дээрх улс орнуудын хууль тогтоомж, практикт тулгуурлан олон улсын жишигт нийцүүлэн Бооцоот морин уралдааны тухай хуулийн төслийг боловсруулсан нь практикт хэрэгжих боломжтой болохыг харуулж байна.

Мөн Монгол үндэстний дэлхийд бахархах өв соёл болох Монгол наадмын морин уралдааны харилцааг хөндөхгүйгээр 18 наснаас дээш насныхан уралддаг бүх улирлын морины уралдааны шинэ төрлийн спорт, түүний эрх зүйн зохицуулалтыг бий болгож, олон улсад хэрэгжүүлж буй эрх зүйн зохицуулалтын сайн туршлагаас Монгол Улсад нутагшуулж, эрх зүйн орчинг бүрдүүлэх нь унаач хүүхдийн эрхийг хамгаалах, соёлын өв болох хурдан мөрийг дэлхийд сурталчлах, түүгээрээ дамжуулан жуулчид татах, түүнчлэн бооцоот морин уралдаан зохион байгуулах бизнесийг дэмжих зэрэг олон талын ач холбогдолтой гэж хуулийн төслийн тандан судалгаагаар тогтоосон байна.

3.4. “Ойлгомжтой байдлыг шалгах” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ:

Хуулийн төсөл нь хэрэгжүүлэх, хэрэглэх этгээдүүдэд ойлгомжтой байдлаар томъёологдсон эсэхийг дараах байдлаар шалгаж тогтоохыг зорьлоо. Үүнд:

1. Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2022 оны 08 дугаар сарын 22-ны өдрийн 1/4295 тоот албан бичгээр хуулийн төсөлд хамаарах этгээдүүдээс санал авсан байх бөгөөд эдгээр байгууллагуудын саналд “Ойлгомжтой байдал” гэсэн шалгах хэрэгслийг ашиглан хуулийн төслийг нэг мөр ойлгож, хэрэгжүүлэх боломжтой байгаа эсэхэд дүн шинжилгээ хийх;

2. Хуулийн төслийг боловсруулахдаа Хууль тогтоомжийн тухай хууль, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлал” -ыг баримталсан эсэхийг шалгах.

1.Байгууллагуудаас ирүүлсэн саналд “Ойлгомжтой байдал” гэсэн шалгах хэрэгслийг ашиглан үнэлгээ хийсэн байдал:

Хуулийн төсөл нь хэрэгжүүлэх, хэрэглэх этгээдүүдэд ойлгомжтой байдлаар томъёологдсон эсэхийг шалгах үүднээс судлаачийн зүгээс хуулийн төслийн ойлгомжтой байдалд дүн шинжилгээ хийсэн болно.

Д/д	Хуулийн төслөөс ойлгомжгүй байгаа зохицуулалт	Тайлбар	Санал
1.	3.1.1.“бооцоо” гэж морин тойруулгад зохион байгуулж байгаа морин уралдааны үр дүнгийн талаар аз туршсан таамаг дэвшүүлж, таамаг нь таарсан тохиолдолд дүрмийн дагуу өсгөж авах, таамаг таараагүй тохиолдолд алдагдал хүлээх эрсдэлийг хүлээж тоглоом зохион байгуулагчид оролцогчоос сайн дураараа шилжүүлж өгсөн мөнгөн хөрөнгийг;	Бооцоот таавар, хонжворт сугалааны тухай хуулийн 4.1.2-д “бооцоо гэж бооцоот үйл явдлын үр дүнгээс шалтгаалж дэвшүүлсэн таавар нь таарсан тохиолдолд дүрэмд зааснаар өсгөж авах нөхцөлтэйгээр эрсдэлээ өөрөө хариуцаж, зохион байгуулагчид сайн дураараа шилжүүлсэн мөнгөн хөрөнгийг” гэж нэг нэр томъёог өөр өөрөөр ойлгохоор тусгасан нь зөрчил, ойлголтын зөрүү үүсгэж болзошгүй байна.	Томъёоллын агуулга ижил төстэй байх тул агуулгыг найруулж, нэг хуулиас нөгөөд иш татсан байдлаар томъёолох.
2.	3.1.4.“оролцогч” гэж бооцоот уралдааны үр дүнгийн талаар аз туршсан таамаг дэвшүүлж, учирч болох	Бооцоот таавар, хонжворт сугалааны тухай хуулийн 4.1.8-д “оролцогч гэж өөрийн азыг туршиж сугалааны тасалбар	Томъёоллын агуулга ижил төстэй байх тул агуулгыг найруулж, нэг хуулиас нөгөөд иш татсан байдлаар

	эрсдэлээ хүлээн зөвшөөрч, морин уралдаанд бооцоо тавьж оролцож байгаа хувь хүнийг;	худалдан авч байгаа, эсхүл бооцоот үйл явдлын үр дүнгийн талаар таавар дэвшүүлэн бооцоо тавьж байгаа хүнийг” гэж нэг нэр томьёог өөр өөрөөр ойлгохоор тусгасан байна.	томьёолох.
3.	4 дүгээр зүйл. Бооцоот уралдааны үйл ажиллагаанд баримтлах зарчим 7 дугаар зүйл. Бооцоот морин уралдааны журам 8 дугаар зүйл. Бооцоот уралдаанд хориглох үйл ажиллагаа	Зүйлийн доторх агуулга нь бооцоот уралдаан зохион байгуулах харилцаанд хамаарч байна.	Зүйлийн доторх агуулгад нийцүүлэн зүйлийн нэрийг “үйл ажиллагаа” гэснийг “зохион байгуулахад” гэж өөрчлөх.
4.	12.1.Монголын морин уралдааны холбоо нь үндэсний өв соёл, уламжлал, морин уралдааныг олон нийтэд сурталчлан дэлгэрүүлэх зорилгоор энэ хуулийн дагуу байгуулагдсан, сайн дурын гишүүнчлэлтэй, өөрийн удирдлагатай, нийтийн эрх зүйн хуулийн этгээд байна.	Төслөөс үзэхэд бооцоот уралдаан зохион байгуулах Холбоо нь нийгэмд үйлчилдэг төрийн бус байгууллагын шинжтэй байх бөгөөд өмчийн хэлбэр нь төрийн оролцоогүй байна.	Энэ тохиолдолд өмчийн хэлбэрийг тодорхой болгох, төрийн оролцоог тодорхойлох
5.	3.1.2.“бооцоот морин уралдаан” /цаашид “бооцоот уралдаан” гэх/ гэж эрх бүхий этгээд тогтоосон дүрмийн дагуу морин тойруулгад зохион байгуулж байгаа морин уралдааныг;	цаашид “бооцоот уралдаан” гэхээр заасан боловч төслийн 3.1.3, 3.1.8, 3.1.9, 3.1.10, 13.1.3-т тус тус “бооцоот морин уралдаан” гэж тусгасан байна.	Холбогдох заалтуудын нэр томьёог жигдлэх.

2.Хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хууль, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлал”-ыг баримталсан эсэхийг шалгасан байдал:

Хуулийн төслийг бүхэлд нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан хууль тогтоомжийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага,

30 дугаар зүйлд заасан хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавих нийтлэг шаардлагад нийцүүлэн боловсруулсан эсэхийг аргачлалын дагуу дараах асуултад хариулт өгөх байдлаар шалгалаа.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан Хуулийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага	
Хууль тогтоомжийн тухай хуулийн зохицуулалт	Хуулийн төслийн зохицуулалтад үнэлгээ хийсэн байдал
29.1.1.Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд нийцсэн, бусад хууль, үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалтай уялдсан байх;	Шаардлага хангасан.
29.1.2.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд хамаарах асуудлыг бүрэн тусгасан байх;	Шаардлага хангасан.
29.1.3.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцааны хүрээнээс хальсан асуудлыг тусгахгүй байх;	Шаардлага хангасан.
29.1.4.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд үл хамаарах хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах буюу хүчингүй болсонд тооцох тухай заалт тусгахгүй байх;	Шаардлага хангасан.
29.1.5.зүйл, хэсэг, заалт нь хоорондоо зөрчилгүй байх;	Шаардлага хангасан.
29.1.6.хэм хэмжээ тогтоогоогүй, тунхагласан шинжтэй буюу нэг удаа хэрэгжүүлэх заалт тусгахгүй байх;	Шаардлага хангасан.
29.1.7.бусад хуулийн заалтыг давхардуулан заахгүйгээр шаардлагатай бол түүнийг эш татах, энэ тохиолдолд эшлэлийг тодорхой хийж, хуулийн нэр болон хэвлэн нийтэлсэн албан ёсны эх сурвалжийг бүрэн гүйцэд заасан байх;	Эшлэлийг хийсэн боловч Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийг эш татахдаа хэвлэн нийтэлсэн албан ёсны эх сурвалжийг бүрэн гүйцэд заагаагүй байх тул энэ шаардлагыг хангах нь зүйтэй.
29.1.8.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаа, хуулийн үйлчлэх хүрээ, эрх зүйн харилцаанд оролцогч хүн, хуулийн этгээдийн эрх, үүрэг, зохицуулалтад удирдлага болгох, харгалзан үзэх нөхцөл байдал, нийтийн эрх зүйн этгээдийн чиг үүрэг, эрх хэмжээ, тэдгээрийг биелүүлэх журам;	Шаардлага хангасан.
29.1.9.шаардлагатай тохиолдолд эрх зүйн хэм хэмжээг зөрчсөн этгээдэд	Шаардлага хангасан.

хүлээлгэх хариуцлагын төрөл, хэмжээ, хуулийн хүчин төгөлдөр болох хугацаа, хууль буцаан хэрэглэх тухай заалт, хуулийг дагаж мөрдөх журмын зохицуулалт, бусад хуулийн зүйл, заалтыг хүчингүй болсонд тооцох, хасах заалт;	
29.1.10.шаардлагатай тохиолдолд бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах болон хууль хүчингүй болсонд тооцох тухай дагалдах хуулийн төслийг боловсруулсан байх;	Ш а а р д л а г а х а н г а с а н .
Хууль тогтоомжийн тухай хуулийн 30 дугаар зүйлд заасан Хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавих нийтлэг шаардлага	
30.1.1.Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуульд хэрэглэсэн нэр томъёог хэрэглэх;	Ш а а р д л а г а х а н г а с а н .
30.1.2.нэг нэр томъёогоор өөр өөр ойлголтыг илэрхийлэхгүй байх;	Ш а а р д л а г а х а н г а с а н .
30.1.3.үг хэллэгийг монгол хэл бичгийн дүрэмд нийцүүлэн хоёрдмол утгагүй товч, тодорхой, ойлгоход хялбараар бичих;	Ш а а р д л а г а х а н г а с а н .
30.1.4.хүч оруулсан нэр томъёо хэрэглэхгүй байх;	Ш а а р д л а г а х а н г а с а н .
30.1.5.жинхэнэ нэрийг ганц тоон дээр хэрэглэх	Ш а а р д л а г а х а н г а с а н .

3.5.”Харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ:

Хууль тогтоомжийн төслийн үр нөлөө үнэлэх аргачлалд заасан дараах асуултад хариулах замаар хуулийн төслийг бүхэлд нь үнэлж, хуулийн төслийн зохицуулалт өөр хоорондоо болон хүчин төгөлдөр үйлчилж байгаа бусад хуульд нийцэж байгаа эсэхийг шалгах байдлаар уялдаа холбоог тогтоохыг зорьлоо.

1.Хуулийн төслийн зохицуулалт тухайн хуулийн зорилттой нийцэж байгаа эсэх.

Хуулийн төсөл нь хуулийн төслийн үзэл баримтлалд тусгасан хэрэгцээ шаардлагад нийцсэн.

2.Хуулийн төслийн “Хууль тогтоомж” гэсэн хэсэгт заасан хуулиудын нэр тухайн харилцаанд хамаарах хууль мөн эсэх.

Хуулийн төслөөр “Хууль тогтоомж” гэсэн хэсэгт заасан хуулиудын нэр тухайн харилцаанд хамаарч байна.

3.Хуулийн төсөлд тодорхойлсон нэр томьёо тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн нэр томьёотой нийцэж байгаа эсэх.

Хуулийн төсөлд тодорхойлсон нэр томьёо тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн нэр томьёотой нийцэж байна.

4.Хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төсөл болон бусад хуулийн заалттай нийцэж байгаа эсэх.

Хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төслийн заалттай нийцэж байна.

5.Хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн заалттай давхардсан эсэх.

Хуулийн төслийн зүйл, заалт өөр хоорондоо болон бусад хуулийн заалттай давхардсан зохицуулалт байхгүй байна.

6.Хуулийн төслийг хэрэгжүүлэх этгээдийг тодорхой тусгасан эсэх.

/Энэ талаар үнэлгээний тайлангийн практикт хэрэгжих боломж шалгуураар үнэлсэн хэсэгт тодорхой тусгасан болно./

7.Хуулийн төсөлд шаардлагатай зохицуулалтыг орхигдуулсан эсэх -

8.Хуулийн төсөлд төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг давхардуулан тусгасан эсэх -

9.Төрийн байгууллагын чиг үүргийг төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодоор гүйцэтгүүлэх боломжтой эсэх

Бооцоот морин уралдааны үйл ажиллагаанд хяналт тавих асуудал нь төрийн зүгээс хяналт, хариуцлага оногдуулах шинжтэй харилцаа тул төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодоор гүйцэтгүүлэх боломжгүй юм.

10.Татварын хуулиас бусад хуулийн төсөлд албан татвар, төлбөр, хураамж тогтоосон эсэх. (Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулна.)

11.Тухайн хуулийн төсөлд тусгасан тусгай зөвшөөрөлтэй холбоотой зохицуулалтыг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд тусгасан эсэх.

Хуулийн төсөлд энэ талаарх зохицуулалт тусгагдаагүй.

12.Монгол Улсын Үндсэн хууль болон Монгол Улсын олон улсын гэрээнд заасан хүний эрхийг хязгаарласан зохицуулалт тусгасан эсэх;

Хуулийн төсөлд энэ талаарх зохицуулалт тусгагдаагүй.

13.Хуулийн төслийн зүйл, заалт жендэрийн эрх тэгш байдлыг хангасан эсэх.

Хуулийн төсөл нь жендэрийн эрх тэгш байдлын асуудлыг хөндөөгүй.

14.Хуулийн төсөлд шударга бус өрсөлдөөнийг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх.

Хуулийн төсөлд энэ талаарх зохицуулалт тусгагдаагүй.

15.Хуулийн төсөлд авлига, хүнд суртлыг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх.

Хуулийн төсөлд энэ талаарх зохицуулалт тусгагдаагүй.

16.Хуулийн төсөлд тусгасан хориглосон хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын талаар тодорхой тусгасан эсэх.

Хуулийн төслийг дагалдах хуулийн төсөлд энэ талаарх зохицуулалт тусгагдсан.

Үр дүнг үнэлж, зөвлөмж өгөх үе шатыг аргачлалын 5 дахь хэсэгт заасны дагуу дараах дарааллаар хийлээ:

- 4.1. үр дүнг баримтжуулах;
- 4.2. үнэлэх;
- 4.3. зөвлөмж өгөх.

4.1. Үр дүнг баримтжуулах: Бооцоот морин уралдааны тухай хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх ажиллагааг “зорилгод хүрэх байдал”, “практикт хэрэгжих боломж”, “ойлгомжтой байдал”, “харилцан уялдаа” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд холбогдох шалгах хэрэгслийг ашиглан хийсэн бөгөөд ийнхүү үр нөлөөний үнэлгээг хийхдээ шаардлагатай хууль тогтоомж, бусад эрх зүйн акт болон хамаарал бүхий холбогдох мэдээлэл, тоо баримт зэрэг материалыг цуглуулж ашиглан, эдгээр материалын жагсаалтыг үнэлгээний тайланд хавсаргав.

4.2. Дүгнэлт: Хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх ажиллагааг аргачлалд заасан 4 шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн ба шалгуур үзүүлэлт тус бүрээр дүгнэвэл:

“Зорилгод хүрэх байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн дүгнэлт:

Бооцоот морин уралдааны тухай хуулийн төсөл нь үзэл баримтлалд тусгагдсан зорилтуудыг хангахад чиглэсэн, холбогдох зохицуулалтыг бүрэн тусгасан боловч зарим зохицуулалт хангалтгүй буюу нарийвчлан зохицуулах шаардлагатай гэж үзлээ. Бооцоот морин уралдаан зохион байгуулах цорын ганц этгээд нь энэ хуулиар байгуулагдах Холбоо байх бөгөөд тухайн этгээдэд хууль тогтоомж болон Зөвлөлөөс тавьсан хууль ёсны шаардлагыг биелүүлэх үүргийг хүлээлгэсэн зохицуулалтын хүрээнд тухайн этгээдэд тавигдах шаардлагыг хуулиар тогтоох хэрэгцээ хангагдах эсэхийг дахин нягтлах шаардлагатай мөн унаач нь морь уралдуулах чадвар, дадлыг эзэмшүүлэх морин уралдааны боловсрол олгох коллеж төгссөн, мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй этгээд байх шаардлагыг тусгасан нь хэрэгцээ шаардлагыг хангаж байгаа хэдий ч хэрэгжүүлэх этгээдийн тухайд тодорхойгүй нөхцөл байдал үүсч болзошгүйг дурдсан болно.

“Практикт хэрэгжих боломж” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн дүгнэлт:

Энэхүү шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн 5.1, 12.1, 13.1 дэх хэсгийг үнэлсэн бөгөөд Иймд туршилт явуулахад хамрагдах холбогдох байгууллага, этгээд байхгүй тул туршилт явуулах боломжгүй гэж үзээд, адил төстэй үйл ажиллагаа явуудаг хуулийн этгээдийн

мэдээлэлд үнэлгээ хийхээс гадна, олон улсын туршлага, эрх зүйн зохицуулалтын хүрээнд уг заалтыг хэрэгжүүлэх боломжтой гэж дүгнэв.

“Ойлгомжтой байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн дүгнэлт:

Энэхүү шалгуур үзүүлэлтийн хүрээнд холбогдох байгууллагуудын ирүүлсэн санал, Хууль тогтоомжийн тухай хуулийн 29, 30 дугаар зүйлд заасан шаардлага, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан шалгуурыг хангасан эсэхэд үнэлгээ хийж холбогдох дүгнэлтийг тайлангийн 3.3. дахь хэсэгт /18–20 дугаар хуудас/ тодорхой тусгасан болно.

“Харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн дүгнэлт:

Хуулийн төслийн зүйл заалт өөр хоорондоо болон Үндсэн хууль, бусад хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль тогтоомжтой зөрчилдөөгүй, заалтууд давхардаагүй, хуулиар зохицуулах шаардлагатай зохицуулалтыг орхигдуулаагүй гэж үзэж байна. Монгол Улсын Үндсэн хууль болон Монгол Улсын олон улсын гэрээнд заасан хүний эрхийг хязгаарласан зохицуулалт болон шударга бус өрсөлдөөн, авлига, хүнд суртлыг бий болгоход чиглэсэн заалт хуулийн төсөлд тусгагдаагүй байна. Мөн хуулийн төсөлд албан татвар, төлбөр, хураамж тогтоогоогүй боловч татвар ногдуулахтай холбоотой зохицуулалтыг тусгасан байх тул татвар ногдуулах, хураахтай холбоотой зохицуулалтыг нарийвчилсан татварын тухай хуулиар зохицуулах нь зүйтэй.

4.3.Зөвлөмж:

Дээрх дүгнэлтэд үндэслэн хуулийн төслийн зарим зохицуулалтыг тодорхой болгох, холбогдох хуульд нийцүүлэх, зарим зохицуулалтыг өөрчлөх зэргээр хуулийн төслийг хуулийн төслийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах улмаар хуулийн төслийг боловсронгуй болгох, чанарыг сайжруулах зорилгоор дараах зөвлөмжийг хууль санаачлагчид өгч байна. **Үүнд:**

Хуулийн төслийн зарим зүйл, заалтад нэмэлт, өөрчлөлт оруулах санал:

1. Хуулийн төсөлд Бооцоот морин уралдаан зохион байгуулагчид тавигдах шаардлагыг дахин нягтлах;
2. Хуулийн төслийн 21 дүгээр зүйлийн 21.2, 21.3 хэсгийг хасах;
3. Бооцоот таавар, хонжворт сугалааны тухай хуулийн төслийг дагалдуулж боловсруулсан Онцгой албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн “бооцоот морин уралдааны үйл ажиллагаа”

- гэснийг_хуулийн төслийн 3.1.3-т заасан нэр томъёонд нийцүүлэн “бооцоот морин уралдаан зохион байгуулах үйл ажиллагаа” гэж өөрчлөх;
4. Хуулийн төслийн 23 дугаар зүйлд “Бооцоот морин уралдааны үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх журмыг Зөвлөл батална.” гэж нэмэх;
 5. Төслийн 3.1.1-д "бооцоо" гэх нэр томъёоны тайлбарыг Бооцоот таавар, хонжворт сугалааны тухай хуулийн 4.1.2-т заасан "бооцоо" гэх тодорхойлолттой уялдуулж нэг хуулиас нөгөөд иш татсан байдлаар томъёолох;
 6. 4 дүгээр зүйлийн нэрийг агуулгад нийцүүлэн “үйл ажиллагаа” гэснийг “зохион байгуулахад” гэж өөрчлөх;
 7. Хуулийн төслийн 3.1.3, 3.1.8, 3.1.9, 3.1.10, 13.1.3 заалтуудын нэр томъёог жигдлэх.

Бусад санал:

1. Унаач буюу жокейчины ажлыг албан ёсны ажил мэргэжилд тооцуулах хүрээнд “Үндэсний ажил, мэргэжлийн ангилал”-д нэмэх асуудлыг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу шийдвэрлэх;
2. Хуулийн төслийн 5.1-д заасан “Монголын морин уралдааны холбоо” гэх оноосон нэрийг давхцалтай эсэх талаар эрх бүхий төрийн байгууллагаас лавлагаа гаргуулах;
3. Бооцоот морин уралдааны үйл ажиллагаанд оролцох хурдан морьдын бүртгэлтийн харилцааг хуулийн төсөлд тусгах.

ТАВ.АШИГЛАСАН МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ

- Хууль тогтоомжийн тухай хууль
- Хууль тогтоомжийн тухай хууль, аргачлал, гарын авлага, Хууль зүй, дотоод хэргийн яам, 2016 он
- Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал” Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын гуравдугаар хавсралт
- Хууль зүй, дотоод хэргийн сайд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын хамтран баталсан Бооцоот морин уралдааны тухай хуулийн төслийн үзэл баримтлал.
- Бооцоот таавар, хонжворт сугалааны тухай хуулийн төсөл /2022.09.15–ны өдрийн байдлаарх/
- Бооцоот морин уралдааны тухай хуулийн төсөл /2022.09.15–ны өдрийн байдлаарх/
- Бооцоот морин уралдааны тухай хуулийн төслийн танилцуулга
- Бооцоот морин уралдааны тухай хуулийн төслийг боловсруулах хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судалсан судалгааны тайлан.
-

---ooOoo---